



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/52

Арвайхээр

Г

Журам батлах тухай

Т

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.10, 16.16 дахь заалт, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/256 дугаартай “Эх нярайн тусламж үйлчилгээний тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/495 дугаартай “Сувилахуйн удирдлага зохион байгуулалт тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/497 дугаартай “Сувилахуйн тусламж үйлчилгээнд үйл ажиллагааны 5 шатлалыг хэрэгжүүлэх тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сувилахуйн албаны бүтэц үйл, ажиллагааны журмыг нэгдүгээр, сувилгааны түүх хөтлөх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан журам заавар, маягтуудыг үйл ажилгаандаа мөрдөн, сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж ажиллахыг клиник албадын эрхлэгч, тасгийн арга зүйч нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сувилахуйн албаны дарга (Б.Тунсагбямба), Сувилахуйн гардан үйлдлийн арга зүйч (Б.Алтангана, Ч.Болортуяа, Б.Сувд-Эрдэнэ), Арга зүйч, эх баригч (Б.Даваасүрэн) нар тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбоотой 2018 оны захирлын А/54 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ



Г.ДАШЖАНЦАН